



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаах авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэгжээс хүлээлгэн өгсөн 16 нэрийн, барилга байгууламжийн үнийг 9,985,132,400.00 (есөн тэрбум есөн зуун наян таван сая нэг зуун гучин хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн
28 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Ашиглалтад орсон он	Балансын үнэ
1	Төв оффисын барилга	А, В, С гэсэн 3 жигүүртэй 3979 мкв талбайтай 2 давхар барилга	2015	3,951,638,100.00
2	Амралтын байр -1	1155 мкв талбайтай 2 давхар барилга	2015	799,925,000.00
3	Амралтын байр -2	1297 мкв талбайтай 2 давхар барилга	2015	799,925,000.00
4	Амралтын байр -3	1212 мкв талбайтай 2 давхар барилга	2015	799,925,000.00
5	Амралтын байр -4	1084 мкв талбайтай 2 давхар барилга	2015	799,925,000.00
6	Дулаан авто гараж	14 автомашины зогсоолтой 300 мкв талбайтай 1 давхар барилга	2015	257,985,000.00
7	Дулааны узелийн барилга	236 мкв талбайтай 1 давхар барилга	2015	186,445,000.00
8	Цэвэр усны нөөцийн барилга	220 мкв талбайтай 1 давхар барилга	2015	136,594,000.00
9	Лабораторийн барилга	280 мкв талбайтай 1 давхар барилга	2015	173,847,000.00
10	Агуулахын барилга	395 мкв талбайтай 1 давхар барилга	2015	171,674,000.00
11	Оффисын барилга-1	487 мкв талбайтай 1 давхар барилга	2015	328,192,000.00
12	Оффисын барилга-2	488 мкв талбайтай 1 давхар барилга	2015	328,192,000.00
13	Оффисын барилга-3	489 мкв талбайтай 1 давхар барилга	2015	295,373,000.00
14	Агуулахын барилга	75.6 мкв талбайтай 1 давхар барилга	2015	32,857,000.00
15	Бохир ус цэвэрлэх барилга байгууламж	80 мкуб хүчин чадалтай 1 давхар сендвичэн барилга	2015	903,420,300.00
16	Харуулын байр	80 мкв талбайтай 1 давхар барилга	2015	19,215,000.00
Нийт дүн				9,985,132,400.00 (есөн тэрбум есөн зуун наян таван сая нэг зуун гучин хоёр мянга дөрвөн зуун)